

БАЯН-АЛДАР ББСБ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2019 оны 4 сарын 8 өдөр

Улаанбаатар хот

Хурлын тооллогын комиссын дарга Л.Идэрзаяа хурлын ирцийг танилцууллаа. Хурлын ирц 50,55%-ын ирцтэй байна. Саналын эрхтэй нийт хувьцаа эзэмшигчдийн 50% -иас дээш нь ирсэн тул хурал хүчин төгөлдөр болж хурал 10:10 минутад эхэлсэн. Хурлын дарга Ч.Чинзориг хурлыг нээснийг мэдэгдлээ.

Ч.Чинзориг: Төлөөлөн удирдах зөвлөлөөс ХЭХ –ыг 2019 оны 4-р сарын 8-ны өдөр хуралдуулахаар тогтоосны дагуу хурал эхлэж байгааг мэдэгдэе. Хурлаар 9 асуудал хэлэлцэх ба хэлэлцэх асуудлуудыг танилцуулаад, нэмэлт санал байгаа эсэхийг тодруулж асуулаа. Нэмэлт саналгүй тул батлав. Хурлын материал дээр хурлын дэг, хурлын хэлэлцэх асуудлуудыг оруулсан байгаа.

Хэлэлцэх асуудал 1. Компанийн 2018 оны үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дүгнэлтийг танилцуулах

Компанийн 2018 оны жилийн үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дүгнэлтийг Гүйцэтгэх захирал Б.Золжаргал танилцуулна.

Б.Золжаргал: Баян-Алдар ХК 1996 оны 4 сард үүсгэн байгуулагдсан. Үүнээс хойш гадаад худалдаа, зочид буудлын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 2017 оны 10 сарын 26-ны өдрийн хурлаар Монгоруматрикс Гинко ББСБ-г өөртөө нэгтгэх шийдвэр гарсан. 2018 оны 12 сарын 14-нд СЗХ-с уг банк бусыг нэгтгэх шийдвэр гараад тогтоолын дагуу Хувьцаа эзэмшигчийн эрхийг 2018 оны 12 сарын 24-өөс 2019 оны 2 сарын 04-ний хооронд хэрэгжүүлж нийт 7-н хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлсэн. Мөн Баян-Алдар ХК-г Баян-Алдар ББСБ ХК болгон компанийн нэрийг өөрчилж үйл ажиллагааны чиглэлийг зээл, гадаад валютын үйл ажиллагаа, санхүүгийн зөвлөгөө гэж үйл ажиллаганы хэлбэр өөрчилсөн. Мөн 2019 оны 02 сарын 14-нд нэгдэж байгаа болон нэгтгэж байгаа компаниуд нь эд хөрөнгөө хүлээлцсэнээр нэгдэх үйл ажиллагаа бүр мөсөн дууссан. Нэгдсэний дараа хувьцаа эзэмшигчдийн хувь эзэмшиж байгаа хувь нь 50,5%-г Ч.Чинзориг 49,2%-г Ш.Таро 0,3% -г 704 хувьцаа эзэмшигч эзэмшиж байна.

Б.Золжаргал: Хувьцаа эзэмшигч нараас нэмж хэлэх санал, асуух асуулт байна уу?

Хэлэлцэх асуудал 2. Компанийн 2018 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн Аудитын дүгнэлтийг танилцуулах

Ц.Билэг-Өрнөх: Аудитын хорооны гишүүн Ц.Билэг-Өрнөх Санхүүгийн дүгнэлт танилцуулна. Тайлант хугацаанд Баян-Алдар ХК ТУЗ-ийн дэргэдэх Аудитын Хорооны

даргаар П.Чинзориг гишүүдээр нь Ч.Лодойравсал, Ц Билэг-Өрнөх нар ажилласан. Хөндлөнгийн аудитаар Ай Жэй Эй Эйч-Аудит ХХК нь хяналт тавьж ажилласан. Тайлант хугацаанд хувьцаа эзэмшигчид болон ТУЗ-өөс өмч хөрөнгийн ашиглалт зарцуулалт, компанийн удирдлага, албан тушаалтнуудын явуулж байгаа бодлого, үйл ажиллагааны талаар ямар нэгэн санал гомдол хүсэлт ирээгүй болно. Тус компани нь 2018 онд нийт 20,4 сая төгрөгийн зардал гаргасан байна. Тайлант хугацаанд ямар нэгэн орлого олоогүй байна. Тайлант хугацаанд гарсан үйл ажиллагааны зардлыг ангилж үзвэл.

Цалин нийгмийн даатгалын шимтгэлд-18,8 сая төгрөг, зар сурталчилгаа-340,0 МХБ-д 512,0 мянган төгрөгийг, ҮЦТХТ-д 433,1 мянган төгрөг бусад зардалд 298,9 мянган төгрөгийн зардал тус тус гаргасан байна.

Авлага, өглөгийн талаар: Оны эхэнд 80,3 сая төгрөгийн өглөгтэй байсан ба оны эцэст 100,6 сая төгрөг болж 20,3 сая төгрөгөөр өссөн байна. Дансны өрийг ангилж үзвэл татварын өр 301,8 мянган төгрөг, хувьцаа эзэмшигчээс-100,3 сая төгрөгийн өглөг тус тус эзэлж байна.

Үндсэн хөрөнгийн талаар: 2018 оны эцсийн байдлаар 3,1 сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэй болно. Компанийн 2018 оны санхүүгийн болон, удирдлагын үйл ажиллагааны тайлант компанийн тухай хууль болон холбогдох журам зааврын дагуу бүртгэлээ хөтөлж санхүүгийн тайлангаа хуульд заасан хугацаанд тайлагнаж харьяа санхүүгийн болон татварын байгууллагад тушаасан байна. ТУЗ-ын дэргэдэх Аудитын Хорооноос цаашид дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөж байна.

1. ТУЗ-ийн, төсвийн зардлыг хийж батлах
2. Өмнөх хуримтлагдсан дансны өглөгийг барагдуулах
3. Компани 2019 онд орлого, ашгийг нэмэгдүүлэх, компанийн ашигтай ажиллагааны түвшинг дээшлүүлэх талаар арга хэмжээ авч ажиллахыг зөвлөж байна.

Б.Золжаргал: Нэмэлтээр хоёр компани нэгдсэнээс хойш 2019 оны 1-р улирлын байдлаар компани 12,0 сая төгрөгний ашигтай ажилласан, хүүний орлогоос олсон орлого 112 сая төгрөг байна.

Б.Золжаргал: Хувьцаа эзэмшигч нараас нэмж хэлэх санал, асуух асуулт байна уу?

Ч.Чинзориг: Нэмж тайлбар хэлэхэд өмнөх жилүүдтэй харьцуулахад харицангүй бага ашигтай гарсан. Яагаад гэвэл 1 сар, 2 сар нэгдэх процесстой холбоотойгоор зээл гараагүй. СЗХ-с 12 сарын 14-нд тогтоол гарсан боловч СЗХ болон УБЕГ хоорондоо бичиг цаас солилцсоор байгаад манай гэрчилгээ тусгай эрхийг баталгаажуулж өгөхгүй, өөрөөр хэлбэл үйл ажиллагаа явуулах бололцоогүй байсан. Хугацаа алдсан ч бид ард нь гарчихсан болохоор цаашид үйл ажиллагаа тогтворжоод 2-р улирал болон жилийн эцэст ашигтай ажиллах зорилт тавин ажиллана.

Хэлэлцэх асуудал 3. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын №01 тоот “Ногдол ашиг хуваарилахгүй” тогтоолыг танилцуулах

Ч.Чинзориг: 2018 оны 2-р сарын 08 ны өдрийн №01 тоот ТУЗ-ийн ноогдол ашиг хувиарлахгүй тухай тогтоолыг Ч.Чинзориг танилцууллаа. Компани нь 2018 онд 117,456,008 төгрөгийн хуримтлагдсан алдагдалтай ажилласан тул ноогдол ашиг хувиарлахгүй байхаар шийдвэрлэсэн байна.

2018 онд нэгдэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд бүх хүчээ дайчлан ажилласан бөгөөд ашиг орлого олоогүй.

Ч.Чинзориг: Хувьцаа эзэмшигч нараас нэмж хэлэх санал, асуух асуулт байна уу?

Хэлэлцэх асуудал 4. Компанийн нэр солих талаар хэлэлцэх

Ч.Чинзориг: Баян-Алдар”ХК нь “Монгорүматрикс Гинко ББСБ” ХХК нэгтгээд Баян-Алдар ББСБ ХК болж үйл ажиллагаа явуулж байгаа. Манай компанийн хувьцааны тал хувь болох 49 % буюу тал хувийг япон улсын иргэн эзэмшиж байгаа. Компанийн хувьд хувьцаа хуваах, хувьцаа нэмж гаргах гээд олон зорилтууд байна. Эдгээр зорилтуудыг дэвшүүлэхэд гаднаас удаан хугацаанд тогтвортой хөрөнгө оруулагч олох шаардлагатай. Компанихаа нэрийг хэлээд танилцуулахад Баян-Ардару гэж хэлж байсан, хэлж чадах япон хүн ховор байсан . Хүмүүст шууд хүрэх үүднээс амар хялбар дуудагдах товч нэрийг сонгож танилцуулхыг хүссэн. Компаниараа бид бүхэн ярилцаж байгаад

- ТАНДЭМ ИНВЕСТ
- ЮМЭ ФИНАНС
- ХҮРЭЭ ФИНАНС

гэсэн гурван нэр дээр тогтоод байна.

Хэлэлцэх асуудал 5: Хувьцааг хуваах тухай хэлэлцэн батлах

Ч.Тэмүдэр:Хувьцаа хуваах гэдэг нь:

- Гаргасан хувьцааны тоо ширхэг нэмэгдэж нэгж хувьцааны үнэ буурна.
- Компанийн зах зээлийн үнэлгээ болон хувьцаа эзэмшигчдийн эзэмшилд өөрчлөлт орохгүй.
Компани хувьд хувьцааг үндсэн 3 шалтгаанаар хуваадаг
- Хувьцааны хөрвөх чадварыг сайжруулах
- Нэмэлт хувьцаа гаргах үед хувьцааны хөрвөх чадварыг хадгалах, дээшлүүлэх хэмжээний тоо ширхэгийг нэмж гаргах
- Шинэ хувьцаа эзэмшигч орж ирэх боломж бүрдэх
Ялангуяа гадаад хөрөнгө оруулагчийг оролцуулахын тулд хувьцаагаа хувааж нэмэгдүүлэх зайлшгүй шаардлагатай байгаа.
Хувьцаа хуваах ерөнхий процессийг танилцуулахад ТУЗ-аас хувьцаа хуваах дүрмийн төсөл батлаад ХЭХ-р оруулаад хувьцаа хуваах төсөл, дүрмийн төслийг эцэслэн батлаад МХБ-д бүртгэлийн журмын дагуу холбогдох материалыг хүргүүлж зөвшөөрөл гарсны дараа СЗХ-д бүртгэлийн журмын дагуу холбогдох материалыг хүргүүлнэ.Энэ ерөнхий процесс нь 1-ээс 2 сар үргэлжилнэ.
Хувьцаа хуваах болсон үндэслэл.

Баян-Алдар ХК нь сүүлийн арилжааг хураангуйлан гаргасан. Үүнээс харвал 2015-2018 оны хооронд нийтдээ 2542 ширхэг хувьцаа арилжлагдсан байгаа. Хувьцааны ханш хамгийн дээд тал нь 1,824 төгрөг, буураад хамгийн доод тал нь 634,95 төгрөгөөр арилжигдсан байгаа.

Ч.Тэмүдэр: Хувьцаа эзэмшигч нараас асуух асуулт байна уу?

Хэлэлцэх асуудал 6: Нэмэлт хувьцаа гаргах талаар хэлэлцэн батлах

Б.Золжаргал: Нэмэлт хувьцаа гаргах эхний асуудал нь салбар нэгж байгуулахаар ажиллаж байгаа.

- Завхан аймагт салбар нэгж байгуулах СЗХ-ны зөвшөөрөл 2019 оны 03 сарын 12-нд гарсан. Яагаад заавал Завхан аймагт салбараа байгуулж байгаа вэ гэхээр манай үлдсэн хувьцаа эзэмшигчдийн дийлэнх хувь нь Завхан аймагт байдаг учир тэдний эрх ашгийг хэрэгжүүлэх үүднээс эхний салбарынхаа зөвшөөрлийг авсан.
- Улаанбаатарт өөр салбар байхгүй. Үндсэн салбар дээрээ үйл ажиллагаа явуулж байгаа. Ерөнхийдөө эргэлтийн хөрөнгөө нэмэгдүүлэхгүй бол нэлээн дутмаг, гурав дөрөв, таван сар болоод л эргэлтийн хөрөнгө дуусчихдаг. Дандаа жижиглэнгийн болон хэрэглээний зээлүүд гаргадаг. Манайх 2,5-3%-н хүүтэй үйл ажиллагаа явуулж байгаа. Төлөвлөж байгаагаар эхний 3-н жилийн байдлаар 2019 онд 5,000 тэрбум төгрөг, 2020 онд 9,000 тэрбум төгрөг, 2021 онд 10,000 тэрбум төгрөгийг давуу эрхийн хувьцаагаар татан төвлөрүүлэхээр төлөвлөсөн байгаа. Монгорүматрикс Гинко ББСБ ХХК-ийн үйл ажиллагааг сүүлийн 3-н жилд авч үзэхэд 2016 оноос эзэмшигч нь солигдоод 2017 оноос эхлээд идэвхитэй үйл ажиллагаа явуулж эхэлсэн. Сүүлийн 2 жилийн байдлаар нийт эргэлтийн хөрөнгө 2,3 тэрбум төгрөг болсон. Ийнхүү ашгийн үзүүлэлт тасралтгүй нэмэгдээд явж байна. Өнгөрсөн оны байдлаар 395,5 сая төгрөгийн ашигтай ажилласан. Нийт эргэлтийн хөрөнгө зээл нь гараад дуусчихдаг, үйл ажиллагааны чиглэл нь бизнесийг дэмжих зорилгоороо том том зээлүүд гаргах учир зайлшгүй нэмэлт хувьцаа гаргах шаарлагатай болж байгаа юм. Нэмэлт давуу эрхийн хувьцаа гаргахтай холбоотой гурван жилийн хугацаатай төсөөлөл хийгээд 2021 он гэхэд эздийн өмч ерөнхийдөө 26 тэрбум болгоно гэсэн төлөвлөгөөтэй байна.

Б.Золжаргал: Хувьцаа эзэмшигч нараас нэмж хэлэх санал, асуух асуулт байна уу?

Хэлэлцэх асуудал 7: Компанийн дүрмийн өөрчлөлтийг хэлэлцэх

Ч.Чинзориг: Компанийн дүрмэнд дараах өөрчлөлтүүдийг оруулна. Үүнд:

- Компанийн Нэр өөрчлөх
- Хаяг дээр салбаргүй байсан салбартай болгон өөрчлөх
- Компанийн нийт зарласан хувьцааны тоо ширхэг өөрчлөгдөнө
- Энгийн хувьцаатай байсан нэмж давуу эрхийн хувьцаа гаргахтай холбогдолтой өөрчлөлтүүд

- Ногдол ашиг хувиарлахгүй
- ТУЗ нь улиралд 1-с доошгүй удаа хуралдана гэснийг нэмэх
- Бусад

Дүрмийн өөрчлөлтийн талаар асуух зүйл байна уу.

Маралхүү: Завханд салбараа хэзээ нээх вэ?

Ч.Чинзориг: Завханд санхүүгийн асуудлаа шийдээд салбараа нээнэ.

Хэлэлцэх асуудал 8: Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох, бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох.

Ч.Чинзориг: Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн энгийн гишүүдэд Ч.Чинзориг, Ч.Бадмаараг, Л.Очирмаа, Ц.Билэг-Өрнөх, Ч.Тэмүдэр, Б.Золжаргал. Гишүүд дээр Тэмүдэр, Б.Золжаргал 2 нэр дэвшигдсэн. Бусад ердийн болон хараат бус гишүүд өөрчлөгдөхгүй. Төлөөлөн удирдах зөвлөлийн нэр дэвшүүлэх хорооноос дээрх 9 хүний нэрийг дэвшүүлсэн. Нэр дэвшигч нарын танилцуулга нь хурлын материал дээр байгаа учир хувьцаа эзэмшигч нар танилцаад саналын хуудсанд саналаа өгнө үү.

Ч.Чинзориг: Хувьцаа эзэмшигч нараас нэмж хэлэх санал, асуух асуулт байна уу?

Хэлэлцэх асуудал 9: Компанийн 2019 оны зардлын төсөв болон ТУЗ-н зардын төсөв батлах

Б.Золжаргал: 2019 оны компанийн зардлын төсвийг гаргахдаа өмнөх хоёр жилийн зардалтай уяалдуулан гаргасан байгаа. 2019 онд шинээр нэмэгдэж байгаа зардлуудад түрээсийн зардал, цалин хөлс болон Баян-Алдар ХК-ийн Монгорүматрикс Гинко ББСБ ХХК-тай нэгтгэхээс өмнөх дансны өглөг болох 100,5 сая.төгрөгийг 2019 онд багтааж төлж барагдуулахаар байна. Мөнх андройтерийн 150,0 сая.төг зардал багтасан байгаа. Энэ нь компани нэмэлт давуу эрхийн хувьцаа гаргах болон компанийн хувьцааг хуваахтай холбогдон гарах зардлууд болно.

Б.Золжаргал: ТУЗ-н зардлын төсвийн хувьд нийт 9 гишүүний цалингийн зардал, бичиг хэргийн зардал, албан томилолтын зардал багтсан байна. Албан томилолт зардлын хувьд нэмэлт давуу эрхийн хувьцаа гаргахтай холбогдуулан хөрөнгө оруулагч татах ажил нилээн хийгдэх учир уг зардлыг тусгаж өгсөн. Өмнөх жилүүдийг харахад улиралд дунджаар 1-2 удаа Япон улс руу явж хөрөнгө оруулалт татах уулзалтанд оролцсон байна.

Ч.Чинзориг: Тооллогын комисс саналын хуудсаа хурааж аваад тооллогын дүнг гаргаад танилцуулна уу.

Тооллогын комиссын дарга Л.Идэрзаяа байна: 2019 оны 4-р сарын 8-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэн асуудлуудын саналын дүнг танилцуулъя

Хэлэлцэх асуудал 1: Компанийн хувьцаа эзэмшигчдийн 50,55 %-ийн саналаар буюу хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдийн 100% ийн саналаар батлагдлаа

Хэлэлцэх асуудал 2: Компанийн хувьцаа эзэмшигчдийн 50,55 %-ийн саналаар буюу хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдийн 100% ийн саналаар батлагдлаа

Хэлэлцэх асуудал 4: Компанийн хувьцаа эзэмшигчдийн 50,55%-ийн саналаар буюу хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдийн 100% ийн саналаар батлагдлаа

Хэлэлцэх асуудал 5: Компанийн хувьцаа эзэмшигчдийн 50,55 %-ийн саналаар буюу хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдийн 100% ийн саналаар батлагдлаа

Хэлэлцэх асуудал 6: Компанийн хувьцаа эзэмшигчдийн 50,55 %-ийн саналаар буюу хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдийн 100% ийн саналаар батлагдлаа

Хэлэлцэх асуудал 7: Компанийн хувьцаа эзэмшигчдийн 50,55 %-ийн саналаар буюу хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдийн 100% ийн саналаар батлагдлаа

Хэлэлцэх асуудал 8: Компанийн хувьцаа эзэмшигчдийн 50,55 %-ийн саналаар буюу хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдийн 100% ийн саналаар батлагдлаа

Хэлэлцэх асуудал 9: Компанийн хувьцаа эзэмшигчдийн 50,55 %-ийн саналаар буюу хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдийн 100% ийн саналаар батлагдлаа

Хурлын дарга Ч.Чинзориг: Нийт хэлэлцсэн асуудлууд санал хураалтын тооллогын дүнгээр батлагдсан байна. Тогтоолын төслийг танилцуулаад батлаад явъя гэж бодож байна.

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар нийт 8 тогтоол баталлаа.

Хурал хаасныг мэдэгдье: 10:55 минутад

Хурлын тэмдэглэл хөтлөсөн:

Н.Нандинцэцэг /Н.Нандинцэцэг/

/Хурлын нарийн бичгийн дарга/

Хурлын дарга

Ч.Чинзориг

/Ч.Чинзориг/

